

**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2027 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ  
БАТЛАХ ТУХАЙ”УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН  
ХОЁР ДАХЬ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ЭДИЙН  
ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 05 дугаар  
сарын 21-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Очирбат**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 194 дүгээр захирамжаар “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, дэд ахлагч Н.Наранбаатар нараар ахлуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, П.Ганзориг, Т.Мөнхсайхан, Ц.Мөнхтуяа, М.Нарантуяа-Нара, Г.Очирбат, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ч.Ундрэм, Г.Уянгахишиг нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 20, 21-ний өдрүүдийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлд заасныг баримтлан дээрх тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барилга барихад эрчим хүчний хэмнэлттэй байх, дулаан алдагдал багатай байх шаардлага тавьдаг асуудал дээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны байр суурь, бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хэт олон зорилт оруулдгаас хэрэгжилт нь хангалтгүй байдаг талаар дурдаж, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах замаар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, дунд хугацааны төсвийн хүрээнд уялдуулан жил бүрийн төсвийг батлах, үүнд хагас жил тутам хяналт тавьдаг болгож өөрчлөх саналын талаар Эдийн засаг, хөгжлийн яамны байр, суурийг асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт заасныг баримтлан Төрийн байгуулалтын байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаануудаараа тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлт ирүүлснийг танилцуулж байна.

## ***1/Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт***

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийг баримтлан 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа "Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан байна.

Тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө ямар байх ёстой, улсын төсвөөс юугаар ялгаатай байх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар төрийн албан хаагчдын 9 хувийн цомхотгол болон дахин инженерчлэлийн үр дүн, сонгуулийн санал тоолох машин ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгуульд хэвийн ажиллаж чадах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл төрийн албан хаагчдын цомхотгол, чиг үүргийн давхардалд анхаарах, тухайн асуудал орон нутагт хүндрэл үүсгэж байгаа тухай болон хэмнэлтийн талаар ямар бодлого барьж ажиллах төлөвлөгөөний талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа улсын төсвийг батлахад хариуцлагатай байх, халамжийн бодлогод шинэчлэл хийх, асрамжийн газрууд санхүүжилтээс болж хаагдах байдал үүссэн талаар болон шаардлагатай бол тухайн харилцааг зохицуулж байгаа дүрэм журмыг өөрчлөх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар мал эмнэлгийн дэвшилтэт технологийн үйлдвэр, Мал эмнэлгийн хүрээлэнгийн судалгаа туршилтын төв байгуулах зорилт, малын вакцин үйлдвэрлэж дотоодын хэрэгцээг хангаж, импортыг орлох зорилтууд Монгол Улсын хөгжлийн 2027 оны жилийн төлөвлөгөөнд тусгасан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Тус Байнгын хороо хуралдаанаараа "Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

## ***2/Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлт***

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийг баримтлан явуулж, тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөнд тусгасан усны төслүүдийн талаар тодруулж, усны тархалтыг тогтоох, зураглалын ажлыг өргөжүүлэх, газрын доорх усны нөөцийг нэмэгдүүлэх ажлыг хаана хийхээр төлөвлөж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай ирэх оны улсын хөгжлийн төлөвлөгөөг Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдуулах, энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлснээр ард иргэдийн, малчин өрхийн амьдралын чанар сайжирч байгаа эсэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх хүрээнд арьс, шир зэрэг малын гаралтай бусад түүхий эдийг үнэ цэнтэй болгох тал дээр хэрхэн анхаарч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа томоохон төслүүдийн үр дүн, хэрэгжилтийг тооцож үзэн цаашид хэрэгжүүлэх эсэхэд анхаарах, ялангуяа "Шинэ хоршоо" хөдөлгөөнийг

оновчтой хэлбэрээр эрчимжүүлэх, ирэх оны хөгжлийн төлөвлөгөөг дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэх, өмнөх жилүүдийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарал хандуулах, Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, стандартын шаардлага хангасан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зээлийн хүү, хугацаа, эргэн төлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен малын арьс, шир, ноос үнэгүйдэх байдлыг анхаарч, малын гаралтай түүхий эдийг боловсруулж байсан өмнөх сайн туршлагыг хэрэгжүүлэх талаар асуулт асууж, хариулт авсан байна.

Тус Байнгын хороо хуралдаанаараа "Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийн зүгээс Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоол болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичигт нийцүүлэн зарчмын зөрүүтэй 62 санал бэлтгэсэн, Улсын Их Хурлын гишүүдийн зүгээс хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд зарчмын зөрүүтэй 145 санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.4 дэх хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг дэмжсэн, дэмжээгүйгээр нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

"Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



Handwritten signature of P. Sadedorj in black ink, written over a red rectangular stamp. The stamp contains vertical text in Mongolian and a numerical code at the bottom: ТУС3761 9023051390 9097\*84.

**Р.СЭДДОРЖ**